



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо,
төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”

Хүнсний аюулгүй байдлыг хянах тогтолцооны
үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Аудитын код: ДГА-2021/12-9-ШТА-ГА

Цахим хуудас:
www.audit.mn

Дорноговь аймаг
2021 оны 11 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер:

У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Аудитор:

Д.Дэмбэрэлсүрэн

Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёог	4
Дүрслэлийн товъёог	4
Бүдүүвчийн товъёог	4
Зургийн товъёог	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
Ерөнхий мэдээлэл	7
БҮЛЭГ А. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт тогтолцооны дагуу хэрэгжиж байгаа ч зөрчил давтагдсаар байна.	7
А.1 Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын зорилт, арга хэмжээний үр дүн нь хангалтгүй байна.	7
А.2 Хүнсний аюулгүй байдлын бодлого, арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянахад төрийн бус байгууллагуудын оролцоо хангалтгүй байна.	11
А.3 Монгол Улс хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан чанарын стандарт, олон улсын жишигт нийцсэн эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр жигд, тогтвортой, хүртээмжтэй, баталгаатай хангагдаж чадаагүй байна.	17
БҮЛЭГ Б. Дэд хөтөлбөр тус бүрээр төсөв баталдаггүйгээс төсвийн зарцуулалт, үр дүн тодорхойлох боломжгүй байна.	31
Б.1 “Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ”-нд нийт дүнгээр төсвийг төлөвлөсөн нь дэд хөтөлбөр бүрийн үр дүнг тооцох боломжгүй байна.	31
Б.2 Хөтөлбөр арга хэмжээний зардлын төсвийн төлөвлөлтийн хавсралтыг гаргаагүй тул хөтөлбөр бүрээр зарцуулалтыг тодорхойлох боломжгүй байна.	33
Аудитын дүгнэлт	34
Аудитын зөвлөмж	35
Холбогдох байгууллагын санал	37
Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар	40
Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулсан тушаал	41

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
ААН	Аж ахуйн нэгж
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗД	Аймгийн Засаг дарга
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
АЗДҮАХ	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
АИТХТ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖХА	Жишсэн хүн ам
ЗГ	Засгийн газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
кг	килограм
л	литр
МТЗ	Монголын төмөр зам
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
СХЗГ	Стандартчилал хэмжил зүйн газар
ТББ	Төрийн бус байгууллага
тн	тонн
УАУРСТ	Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв
УБТЗ	Улаанбаатар Төмөр зам
УИХ	Улсын Их Хурал
УЦУОШ	Ус цаг уур орчны шинжилгээ
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАБТ	Хүнсний аюулгүй байдлын тухай
ХБАБХТХ	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
ХМХА	Хилийн мэргэжлийн хяналтын алба
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЧСХУ	Хүнсний чанар стандарт хяналтын улсын
ш	ширхэг
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Хүснэгтийн товъёог:

Утга	Тайлбар
Хүснэгт № 1	Үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөр баталсан жагсаалт
Хүснэгт № 2	МХГ-аас хяналт шалгалт хийсэн тоон судалгаа
Хүснэгт № 3	Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, аймгийн хүнсний эх үүсвэрийн судалгаа, тооцоо
Хүснэгт № 4	Хүнсний бодит нөөцийн судалгаа
Хүснэгт № 5	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гарсан зардлын жагсаалт
Хүснэгт № 6	2020 оны хими хор судлалын лабораторийн шинжилгээ
Хүснэгт № 7	Аймгийн МХГ-ын сорилтын лабораторид шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа
Хүснэгт № 8	Аймгийн дотоодын үйлдвэрлэлийн хүнсний хангамжийн тооцоолол
Хүснэгт № 9	Нэг хүний хүнснээс авч буй бодит илчлэг шим тэжээл
Хүснэгт № 10	Хяналт шалгалтын хуудсаар илэрсэн нийтлэг зөрчлийн жагсаалт
Хүснэгт № 11	Сум хөгжүүлэх сангаас олгогдсон зээл
Хүснэгт № 12	Хүнсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд гарсан зардал

Дүрслэлийн товъёог:

Утга	Тайлбар
График № 1	Бүртгэгдсэн өвчлөлийн судалгаа
График № 2	Хэвтэн эмчлүүлсэн хүний судалгаа

Бүдүүвчийн товъёог

Утга	Тайлбар
Бүдүүвч № 1	Төрийн байгууллагуудын чиг үүрэг
Бүдүүвч № 2	Хүнсний хангамжийн удирдлага, зохион байгуулалт

Зургийн товъёог:

Утга	Тайлбар
Зураг № 1	Лабораторийн өрөө
Зураг № 2	Ашиглаагүй байгаа шинэ тоног төхөөрөмж
Зураг № 3	Агуулахын эмх цэгц муу
Зураг № 4	Гарал үүсэл нь тодорхойгүй жижиглэн савласан бүтээгдэхүүн
Зураг № 5	Хэрэглэж дуусах хугацаа дууссан бүтээгдэхүүн
Зураг № 6	Агуулахын эмх цэгц муу

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх; - Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгө үр дүнтэй эсэх.
Аудитын хамрах хүрээ	Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газар, Замын-Үүд боомт дахь Хилийн Мэргэжлийн хяналтын албыг хамруулан гүйцэтгэлээ. /аудитаар 2018, 2019, 2020 оны баримт материалыг суурь болгон хамруулсан/
Аудитын хязгаарлалт	Аудитын гүйцэтгэлийн үе шатны явцад аудитор цар тахал Covid-19-ээр өвчилснөөс цаг хугацаа алдсан хязгаарлалт байсан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулна.

	Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд: - Төрийн аудитын тухай хууль; - Төсвийн тухай хууль; - Хүнсний тухай хууль; - Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль; - Органик хүнсний тухай хууль; - Баяжуулсан хүнсний тухай хууль; - Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль; - Эрүүл ахуйн тухай хууль; - Тариалангийн тухай хууль; - Усны тухай хууль; - Зөрчлийн тухай хууль; - Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль; - Бусад холбогдох эрх зүйн актууд /УИХ-ын тогтоол, ЗГ-ын тогтоол, Стандартууд, Сайдын тушаал/
Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитор Т.Мөнхтогтох, аудитор Д.Дэмбэрэлсүрэн нар гүйцэтгэв. Аудитын тайланг 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн дотор нэгтгэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар баталгаажуулж, дарга, тэргүүлэх аудиторовын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/33 дугаар тушаалаар баталгаажуулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.
Хүндрэл бэрхшээл	-

БҮЛЭГ А. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт тогтолцооны дагуу хэрэгжиж байгаа ч зөрчил давтагдсаар байна.

А.1 Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын зорилт, арга хэмжээний үр дүн нь хангалтгүй байна.

А.1.1 Орон нутагт Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах зарим бодлогын баримт бичгийн зорилт арга хэмжээний уялдаа холбоо хангалтгүй байна.

Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын бодлого, эрх зүйн орчин нь Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” болон холбогдох бусад хууль, тогтоол, журам, хүнсний аюулгүй байдалтай холбоотой стандарт зэрэг эрх зүйн актын хүрээнд бүрдэж байна.

УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.18-д Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана гэсэн заалтын хүрээнд АЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрт 1.23.4 дэх заалтаар оруулан 2017 оны А/421 дүгээр захирамжаар “Мах, сүүний анхдугаар аян”-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан гаргасан байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн төвлөрсөн зах худалдааны төв болон сумдад худалдаалагдаж буй мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавьж, Мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн магадлан шинжилгээнд нийт 45 аж ахуйн нэгжийн 267.9 тн мах махан бүтээгдэхүүний 387 дээж, 11.1 тн сүү сүүн бүтээгдэхүүний 211 дээжийг тус тус хамруулснаар мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс шалтгаалсан өвчин аймгийн хэмжээнд бүртгэгдээгүй байна.

Харин ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.21-д “аймаг, нийслэл, сум, суурин газруудын хэрэгцээнд тохирсон орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын хүнсний боловсруулах жишиг загвар үйлдвэрийг байгуулахыг дэмжинэ”, 2.22-д “хүнсний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгоно”, 2.24-д “дотоодын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, тахиа, гахай, зөгий, загасны аж ахуй зэрэг дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэсэн заалтууд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй байна.

Аудитын хугацаанд УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын тайлан ирүүлээгүй, УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг дангаараа тайлагнадаггүй гэсэн тайлбарыг АЗДТГ-ын холбогдох мэргэжилтэн өгсөн тул үнэлэх боломжгүй байна.

А.1.2 Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үндэсний стандарт нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна.

2019 онд Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага MNS ISO 22000, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946, Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ MNS 5021, 2020 онд Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл MNS ISO 22002-4 стандартууд батлагдсан байна.

Аудитын явцад аймгийн МХГ-ын ХЧСХУ байцаагчаас хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үндэсний стандарт өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангасан эсэх талаар ярилцлага хийж тодруулахад стандартуудыг батлахаас өмнө санал авдаг тул холбогдох стандартууд өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа харин Хоол үйлдвэрлэлийн стандартын 8.12 “нийтийн орон сууцны доорх хоол үйлдвэрлэлийг **төлөвлөхгүй**” гэдэг заалт нь бөөрөнхийлсөн заалт байгааг шууд хориглоно гэж өөрчлөх саналтай байгаа талаар дурдсан.

Аймгийн МХГ-аас хүнсний чанар, стандартад хийсэн 20 төлөвлөгөөт хяналт шалгалтаар тухайн чиглэлийн стандартын хэрэгжилтийг шалгасан байна. Харин шалгадагч талаас стандартын хэрэгцээ шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хүндрэл бэрхшээл гарч байгаа талаар санал гараагүй байна.

А.1.3 Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үндэсний хөтөлбөрийн зорилтын хүрээнд дэд хөтөлбөрүүдийг боловсруулсан хэдий ч хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтээ хангаж чадаагүй байна.

Хүнсний аюулгүй байдлын талаар ЗГ-ын тогтоолоор дараах үндэсний хөтөлбөрүүдийг баталсан байна.

Үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөр баталсан жагсаалт

Хүснэгт №1

Тогтоолын он, дугаар	Үндэсний хөтөлбөрийн нэр	Аймгийн дэд хөтөлбөрийн тогтоолын огноо, дугаар
2016 он 287	Сав, баглаа боодол	-
2017 он 223	Жимс жимсгэнэ	2018.10.19, 64
2017 он 278	Хүнсний ногоо	2018.10.19, 65
2018 он 12	Малын эрүүл мэнд	2018.07.02, 49
2019 он 52	Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн	-

Дээрх үндэсний хөтөлбөрүүдтэй уялдуулан АИТХТ-ийн хурлаар “Жимс жимсгэнэ”, “Хүнсний ногоо”, “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд аймгийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулан батлуулсан байна.

“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгаас дэд хөтөлбөрийг боловсруулж батлуулаагүй, үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулсан байна.

“Эрүүл хүнс–Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Орон нутгийн экологийн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулсан гэсэн тайлбарыг холбогдох мэргэжилтнээс ирүүлсэн ч уг хөтөлбөр нь 2018 онд батлагдсан хөтөлбөр байна.

Аудитын явцад орон нутгийн баталсан дэд хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг 2020 оны ажлын тайлантай тулган баталгаажуулахад дараах заалтууд хэрэгжээгүй байна. Тодруулбал:

- АИТХТ-ийн 2018 оны 65 дугаар тогтоол “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийн 6.1.2 орон нутгийн хүн амын хүнсний ногооны жилийн хэрэгцээг 10 хувийг хангадаг болсон байна гэж заасан байхад аудитын явцад хийсэн хүнсний хангамжийн тооцооллоор дотоодын хэрэгцээний 3.9 хувийг хангаж байгаа тооцоо гарсан.
- АИТХТ-ийн 2018 оны 64 дүгээр тогтоол “Жимс жимсгэнэ” дэд хөтөлбөрийн 6.1.1 жимс, жимсгэнэ, тарвасаар хийсэн бүтээгдэхүүний нэр 3-4 төрлөөр нэмэгдсэн байна гэж заасан байхад Аймгийн төв Агропарк амтат гуаны 4 сортыг сорин туршиж 2 сортыг ирээдүйтэй сортоор батлуулахаар бэлтгэл хангасан байна.
- Жимс, жимсгэний дотоодын хэрэгцээний 10 хувийг хангадаг болно гэж заасан байхад аудитын явцад хийсэн хүнсний хангамжийн тооцооллоор дотоодын хэрэгцээний 1.9 хувийг хангаж байгаа тооцоо гарсан.
- Жимс жимсгэний мод тариалдаг өрхийн тоог 100-аар нэмэгдүүлнэ гэж заасан байхад орон нутгийн 76 иргэн, ААН монос, бөөрөлзгөнө, далан хальсны 400 ш суулгацыг туршилтаар тариалсан.
- АИТХТ-ийн 2018 оны 66 дугаар тогтоол “Орон нутгийн экологийн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх” дэд хөтөлбөрийн 5.4 ... дотоодын үйлдвэрлэлийн хангамжийг 5-10 хувьд хүргэнэ гэж заасан байхад аудитын явцад хийсэн хүнсний хангамжийн тооцооллоор дотоодын үйлдвэрлэл 3.8 хувийг хангаж байгаа тооцоо гарсан.

Дээрх хэрэгжээгүй заалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Улсын хэмжээнд баталсан үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулж батлах нь зарцуулах төсөв хөрөнгө шийдэгдэхгүй орхигдох, тухайн хөтөлбөр үр дүнтэй хэрэгжихгүй байх сул талтай байна. Мөн тухайн орон нутаг нь өөрсдийн онцлогт тохирсон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь үр дүнтэй байна.

А.1.4 Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль, эрх зүйн зохицуулалт үр дүнтэй хэрэгжсэн байна.

Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг Хүнсний тухай хуулийн 13.1.2-д “хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт” гэж заасан эрхийн хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын алба хэрэгжүүлж байна.

Аймгийн МХГ-ын 2020 онд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, авсан арга хэмжээг авч үзэхэд:

Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсээс төлөвлөгөөт шалгалт объектод 6 хяналтын чиглэлээр 86 шалгалтыг хийж, зөвлөн туслах 26, урьдчилан сэргийлэх хяналт 5, тандалт 3, улсын байцаагчийн хамтарсан болон бие даасан 128 албан шаардлага, 49 дүгнэлт, 40 акт үйлдэн холбогдох газарт хүргүүлсэн байна. Үүнээс хүнсний чанар, стандартын хяналтаар 20 төлөвлөгөөт хяналт шалгалт хийж хүнсний /А,1,2-т оруулах/ худалдааны газруудаас 107 нэр төрлийн 518 кг, 862 ш, 4.5 сая төгрөгийн чанар байдал алдагдсан, хадгалалтын хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүнийг орон тооны бус зөвлөлд 18 актаар хүлээлгэн өгч устгасан байна.

Сар шинийн баярын урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар лабораторийн шинжилгээнд 8 нэр төрлийн 15 дээжийг хамруулахад стандартын шаардлага хангаж байсан байна. Мөн мах, сүүн бүтээгдэхүүнийг ил задгай худалдаалж байсан 6 иргэний үйл ажиллагааг таслан зогсоосон байна.

Эх үрсийн баярын урьдчилан сэргийлэх хяналтаар 10 сумдад хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй нийтийн хоолны 28, хүнсний худалдааны 84, хүнсний үйлдвэрлэл 8, хүнсний бөөний худалдааны төв 5 нийт 125 объектыг хамруулж, 111 зөрчлийг илрүүлж, 73 хувийг богино хугацаанд арилгуулсан байна.

Эрүүл ахуйн шаардлага хангахгүй орчин нөхцөлд хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилж чанар, аюулгүй байдлын шаардлага хангахгүй, гарал үүсэл тодорхойгүй, шинжилгээ баталгаажилтад хамрагдаагүй хүнсний түүхий эд ашиглан Ази болон Монгол хоолоор нийтийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байсан Баянбулаг шанд ХХК-ий түргэн хоолны газрын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох акт үйлдэж зөрчил арилсны дараа үйл ажиллагааг сэргээх акт үйлдсэн байна.

Чандмань-Илч ХХК-ий ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн бохир уснаас дээж авч аймгийн УЦУОШ-ий лабораторид шинжлүүлэхэд жинлэгдэх бодис, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 8 дахин их, перманганатын исэлдэх чанар 5.4 дахин их, аммонийн ион 6.4 их гарсан ба Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус стандартын шаардлагад нийцээгүй байна.

Төлөвлөгөөт шалгалтад 7 объект хамруулан 111 зөрчил илрүүлэн нийт илэрсэн зөрчлийн 68.4 хувийг арилгуулсан, зөвлөн туслах үйлчилгээний явцад 116 зөрчил илрүүлэн зөрчлийн 87.9 хувийг арилгуулсан байна.

Замын-Үүд сумын ХМХА нь 2020 онд хүнсний бүтээгдэхүүний хяналтын чиглэлээр нийт 3790 ААН, 22 иргэний хилээр нэвтрүүлсэн бараа бүтээгдэхүүнд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийсэн байна.

Замын-Үүд боомтоор 61 ААН-ийн экспортолсон 1953 тн боловсруулсан хүнс, хүнсний түүхий эд бүтээгдэхүүнд баримт бичиг болон биет үзлэг шалгалт хийж улсын хилээр нэвтрүүлсэн байна. Экспортын хяналтад хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний 142.1 тн буюу 72.7 хувь МУ-аас экспортлогдсон, 531.8 тн буюу 27.3 хувь нь транзит ачаа байна. Хяналт шалгалтаар 1 ААН-д холбогдох зөрчилд 1 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна.

Тус боомтоор импортын 3730 ААН, 22 иргэний 107919 тн, 93 л боловсруулсан хүнс, хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг хяналт шалгалтад хамруулсан.

Нийт импортлогдсон хүнсний бүтээгдэхүүний 92.8 хувь буюу 100152 тн бүтээгдэхүүний баримт бичигт хяналт хийж гүний хяналтад шилжүүлэн, 7.2 хувь буюу 7766.7 тн бүтээгдэхүүнд бичиг баримт болон биет үзлэг шалгалт хийж лабораторийн шинжилгээнд хамруулсан байна.

Эрсдэлийн ангиллаар авч үзвэл 6.9 хувь нь бага эрсдэлтэй, 86.7 хувь нь дунд эрсдэлтэй, 6.4 хувь нь их эрсдэлтэй бүтээгдэхүүн байна.

Импортын хяналтаар хил дээр задарч хяналтад хамрагдсан хүнсний түүхий эд бүтээгдэхүүний 77.3 хувь нь лабораторийн шинжилгээнд хамрагдсан байна.

Тайлант хугацаанд 9 ААН, 23 иргэнд холбогдох зөрчлийг илрүүлэн нийт 35.1 сая төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулж, 295.1 тн хүнсний бүтээгдэхүүнийг экспортлогч улсад буцааж, 12.4 тн хүнсний түүхий эд бүтээгдэхүүн хураан авч, 11.3 тн, 43 л бүтээгдэхүүнийг устгасан байна. Хяналт шалгалтаас зайлсхийсэн 1 ААН, 7 иргэнд холбогдох хуулийн дагуу торгууль оногдуулж барагдуулсан байна.

Аймгийн МХГ-т Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтаар 873 объектод 3 байцаагч хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд нэг байцаагчид хяналтад 334 объект ногдож байна. Иймд хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулах үүднээс эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын байцаагчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

2. Хүнсний аюулгүй байдлын бодлого арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянахад төрийн бус байгууллагуудын оролцоо хангалтгүй байна.

А.2.1 Орон нутагт хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод хоорондын ажлын уялдаа холбоог бодлогоор зохицуулаагүй байна.

Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор 2018-2020 онд Хүнс, хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын чиглэлийн 5 дэд хөтөлбөр, аймгийн Засаг даргын захирамжаар 4 урт хугацааны аяныг баталсан байна. Тус хөтөлбөр, аяны хүрээнд ХХААГ, ЭМГ, МХГ, СХЗГ, сумдын Засаг дарга, мэргэжлийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, ТББ-уудтай хамтран ажиллана гэж тусгасан.

Төрийн байгууллагуудын хувьд хөтөлбөр, захирамжаар баталсан дэд хөтөлбөр, аяны арга хэмжээг үр дүнгийн гэрээнд тусган биелэлтийг тооцож эргэн тайлагнагддаг тул уялдаа холбоотой ажиллаж байна.

Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлд “хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллага нь хүнсний тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хэрэглэгч болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн эрхийг хамгаалах асуудлаар саналаа төрийн болон нутгийн захиргааны байгууллагад уламжлах оролцоотой байна” гэж заасан. Гэтэл төрийн нутгийн захиргааны байгууллагад төрийн бус байгууллагаас тухайн асуудлаар санал ирүүлж байгаагүй байна.

Төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоод, хоршоод нь тус хөтөлбөр, арга хэмжээнд ямар эрх хэмжээтэй хэрхэн оролцох талаар уялдаа холбоог зохицуулж өгөөгүй байна.

Харин сургалт сурталчилгаа зохион байгуулах тал дээр хамтран ажилласан байна. Тухайлбал:

- 2020 онд ЭМГ, МХГ, ХХААГ нь аймгийн “Тогооч нарын холбоо”-той хамтран “Хоол эмчилгээний талаар мэдлэг олгох” сургалтыг зохион байгуулж Нэгдсэн эмнэлэг, УАУРСТ, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн тогооч нарыг хамруулан мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан байна.

Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдийн хувьд хэрэгжилтийг зөвхөн төрийн байгууллагууд ханган ажиллахаар тусгаж өгсөн байгаа нь төрийн бус байгууллагууд хүнсний аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллах талаарх бодлого дутмаг байна.

Иймээс бодлогын баримт бичгийг аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүдэд холбогдох төрийн байгууллагууд, бусад төрийн бус байгууллагууд, холбоодын ажлын уялдаа холбоог хэрхэн хангах талаар тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна.

А.2.2 Хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээг зохистой хуваарилсан байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт батлах нийтлэг журам”-д томилох эрх бүхий албан тушаалтан албан тушаалын тодорхойлолтыг батлан гаргахаар тусгасан байна.

Орон нутагт аймгийн ЗДТГ, МХГ, Замын-Үүд сумын ХМХА, ХХААГ, СХЗГ, ЭМГ-ууд хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтийг хангах болон түүнд хяналт тавих чиг үүрэгтэй ажиллаж байна. Тухайн байгууллагуудын хүнс хариуцсан ажилчдын албан тушаалын тодорхойлолтыг томилох эрх бүхий албан тушаалтан нь боловсруулан, баталж гаргадаг байна.

Байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо болон албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолтод заасан ажлын чиг үүргийг дараах зураглалаар харуулав.

Төрийн байгууллагуудын чиг үүрэг

Бүдүүвч №1



Аудитын явцад ажлын байрны тодорхойлолтуудад тулган баталгаажуулалт хийхэд бүтэц чиг үүргийн хувьд давхардал үүсээгүй байна.

Хүнсний аюулгүй байдлын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч аймгийн МХГ-ын Эрүүл мэнд, боловсрол хүнсний хэлтэс нь хүнсний чанар стандартын хяналтын 3 улсын байцаагчийн орон тоотой ажилладаг бөгөөд үүний 1 орон тоо нь Замын-Үүд суман дахь Мэргэжлийн хяналтын тасагт байдаг байна.

Бусад сумдад хүнсний байцаагчийн орон тоо байдаггүй, аймгийн хэмжээнд нэг байцаагчид 334 объектод хяналт шалгалт хийхээр ногдож байгаа нь ажлын ачаалал их байхаар харагдаж байна.

Харин бүх суманд ХХААГ-ын хүнс хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн ажилладаг бөгөөд тус мэргэжилтэн нь хяналт шалгалт хийх байцаагчийн эрхгүй тул хяналт хийх боломжгүй байдаг байна. Гэтэл сумдын хувьд хугацаа дууссан хүнс зарж борлуулах, хүнсний аюулгүй байдал алдагдах, зөрчил гарах эрсдэл их байдаг байна.

МХГ-аас сумдад жилд нэг удаа төлөвлөгөөт хяналт хийдэг ба энэ нь сумдад хүнсний аюулгүй байдлын хяналтыг бүрэн тасралтгүй хэрэгжүүлж чадахгүй байна.

А.2.3 Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулсан зөрчлийг илрүүлэх, бүртгэх, зөрчлийн суурь шалтгааныг тодорхойлоход салбар хоорондын хамтын ажиллагааны үр дүн муу байна.

Аймгийн Засаг дарга МХГ-ын даргатай 2018 онд үр дүнгийн гэрээ байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлан ажилласан. Харин 2019-2020 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан ажилласан байна. Жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүний эрүүл мэндэд хохирол учруулсан зөрчлийг илрүүлэх, бүртгэх, зөрчлийн суурь шалтгааныг тодорхойлж арилгах талаар тусган оруулсан байна.

Уг ажлын хүрээнд аймгийн МХГ-аас урьдчилан сэргийлэх хяналтаар 2019, 2020 онд 318 аж ахуй нэгж, иргэнд хяналт шалгалт хийж 3374 заалт бүхий 54 албан шаардлага хүргүүлж, 25 акт үйлдсэн 265 нэр төрлийн 8617 ширхэг 7.9 сая төгрөгийн зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг хураан авч сумын Засаг даргын дэргэдэх Орон тооны бус зөвлөлд шилжүүлэн ажилласан байна.

Урьдчилан сэргийлэх шалгалтын явцад 2020 онд лабораторийн шинжилгээнд 8 нэр төрлийн 15 дээжийг хамруулан шинжлэхэд стандартын шаардлага хангасан байна. Мах сүүн бүтээгдэхүүнийг ил задгай худалдаалж байсан 6 иргэний үйл ажиллагааг таслан зогсоож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна. Урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлгийг тараах материал болон телевиз, FM, цахим хаягаар сурталчилсан байна.

Аймгийн МХГ-с 2018-2020 онд хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах хяналт шалгалтуудыг хийж гүйцэтгэжээ. Ковид цар тахалтай холбогдуулан сүүлийн жилүүдэд шалгалтад хамрагдах объектын тоо буурснаас зөрчлийн хувь хэмжээ буурч харин зөрчлийг арилгах арга хэмжээний үр дүн өссөн байна.

МХГ-аас хяналт шалгалт хийсэн тоон судалгаа

Хүснэгт №2

Хяналт шалгалтын төрөл	Шалгалтад хамрагдсан объектын тоо			Илэрсэн зөрчлийн тоо			Арилгуулсан зөрчлийн тоо		
	2018	2019	2020	2018	2019	2020	2018	2019	2020
Төлөвлөгөөт хяналт шалгалт									
Хүнсний эрүүл ахуйн хяналт	51	62	41	408	496	369	306	372	317
Хүнсний чанар стандартын хяналт	65	91	56	585	728	448	439	582	336
Нийт	116	153	97	993	1224	817	745	954	653
Төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт									
Хүнсний эрүүл ахуйн хяналт	93	97	105	465	388	420	372	291	336
Хүнсний чанар стандартын хяналт	140	232	179	700	1392	1074	490	1044	752
Нийт	233	329	284	1165	1780	1494	862	1335	1088
Гүйцэтгэлийн хяналт шалгалт									
Хүнсний эрүүл ахуйн хяналт	18	11	14	90	61	84	85	55	80
Хүнсний чанар стандартын хяналт	39	55	34	146	146	112	131	134	101
Нийт	57	66	48	236	207	196	216	189	181

Аймгийн МХГ нь 2018-2020 онд иргэдээс хүнсний аюулгүй байдал алдагдсан талаарх 20 өргөдөл гомдол хүлээн авсан байна. Үүнээс утсаар 6, бичгээр ирүүлсэн 14 гомдлын мөрөөр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж улсын байцаагчийн 8 албан шаардлагыг хүргүүлж, зөрчил дутагдалгүй 3, бусад илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулан, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан байна.

Харин 2018-2020 онд ЭМГ-т хүнсээр дамжуулан хүний эрүүл мэнд хохирсон талаарх өргөдөл гомдол ирээгүй байна.

ЭМГ-аас 2018 онд аймгийн хэмжээнд “Хүн амын дундах илүүдэл жин, таргалалтын судалгаа”-г 4615 хүнээс, “Хүүхдийн дундах чихэрлэг ундааны хэрэглээний түвшин тогтоох судалгаа”-нд 3870 хүүхдийг хамруулан хийсэн байна. Судалгааны үр дүнд хамрагдсан иргэдийн 58.5% нь таргалалттай, хүүхдүүдийн 38.5% нь шүдний цооролтой, чихэрлэг ихтэй ундаа болон хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ ихтэй гэж гарчээ. Уг судалгааг 3 жил тутамд 1 хийдэг байна.

Уг судалгааны дагуу ЭМГ нь Сайншанд сумын ЕБС-ууд хүүхдэд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг хүргүүлэн зөвлөгөөг өгч, хориотой бүтээгдэхүүний хяналтыг холбогдох байгууллагууд, ЕБС-уудын эцэг эхийн зөвлөл, эмч нартай хамтран сургуулийн орчинд худалдаалагддаг бүтээгдэхүүн болон гар дээрээс ил задгай худалдаа хийх байдалд хяналтыг тогтмолжуулснаар хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх 24 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг худалдаалахыг зогсоосон. Бүх сургуулийн ойр орчинд гар дээрээс худалдаа хийхийг хориглон, сургуулийн эмч, School police-аар ажиллаж буй эцэг эхчүүд давхар хяналтыг тогтмол тавьж хэвшсэн байна.

МХГ нь иргэдээс өргөдөл гомдлыг цаасаар, утсаар, цахим хэлбэрээр авдаг бөгөөд өөрийн вэб хуудас болон Фейсбүүк хаягууд дээр санал гомдлыг хүлээн авах хэлбэр болон санал хүсэлтийг хүлээн авах утасны дугаарыг иргэд олон нийтийн нүдэнд ил байхаар байршуулж ажиллах нь зүйтэй байна.

Дээрх байгууллагууд аймаг сумдын холбогдох мэргэжилтэнтэй хамтран хамтран ажиллах ажлыг тогтмол зохион байгуулж, хэвшүүлэн ажиллах шаардлагатай байна.

2.4 Орон нутагт “Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө” гарган салбар дундын зохицуулалтыг хангаж ажилласан байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4.12-д “стратегийн хүнс, бараа, бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөргөдөл болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагад чиглэл болгох, хяналт тавих” гэж заасан байдаг.

Аймгийн хэмжээнд 2018-2020 онд нийтийг хамарсан хордлого, халдварын тохиолдол бүртгэгдээгүй байна.

“Дорноговь аймгийн гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөө”-ний хүрээнд “Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан баталсан байна. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх, хуваарилах, худалдаалах, олгох арга хэмжээг хүнсний бодит нөөцөд тулгуурлан 3 зэрэгт авч үзэж хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Төлөвлөгөөний хүрээнд:

- Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгаа, тооцоо;
- Ундны усны эх үүсвэрийн судалгаа, тооцоо;
- Хүнсний худалдааны томоохон төв, захын судалгаа тооцоо;
- Хүнсний агуулах, зоорины судалгаа тооцоо;
- Хүнсний үйлдвэр, цехийн судалгаа, тооцоог гарган боловсруулалт хийн хавсралтаар

батлуулан төлөвлөгөөг хэрэгжүүлэх байгууллага албан тушаалтнууд шаардлагатай судалгаа, мэдээнүүдийг бүрдүүлсэн байна. Хүнсний хангамжийн удирдлага, зохион байгуулалтыг дараах байдлаар зохион байгуулсан байна.

Бүдүүвч №2



ХХААГ нь АЗД-ын 2020 онд гаргасан "Гамшгаас хамгаалах бэлтгэл ажил", "Хүнсний хангамжийн шуурхай штаб байгуулах тухай", "Гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" захирамжийн хүрээнд бүтэц орон тоо, хүний нөөцийн судалгаа, хүнсний хангамжийн тооцооллыг хийж гамшгаас хамгаалах, бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчлэн баталсан байна.

Гамшгийн үед хүн амыг стратегийн хүнсээр хангах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 6 аж ахуйн нэгжийг сонгон 2020 онд гэрээг шинэчлэн байгуулан ажилласан байна.

2020 оноос эхлэн өргөн хэрэглээний барааны үнийн судалгааг 7 хоног тутамд шинэчлэн гаргаж байна. Мөн үнийн хөөргөдөл, хүнсний нөөц бүрдүүлэх талаар уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Аймгийн Онцгой комиссын 08 дугаар шийдвэрээр Хүнсний зах, худалдааны төвүүдэд махны үнэ өндөр байгаатай холбогдуулан “Суман зурхай” ХХК хамтран нөөцийг махыг иргэдэд зах худалдааны төвөөр дамжуулан хямд үнээр борлуулах, худалдааны захуудад түрээсийн төлбөр төлөхгүйгээр 2020 оны 03 дугаар сараас эхлэн нэр бүхий худалдааны төвүүдэд үхэр болон хонины мах хямд үнэтэйгээр борлуулах ажлыг зохион байгуулсан байна.

Аймгийн Онцгой комиссын даргын тушаал, шийдвэр, албан даалгаврын хэрэгжилт болон цаг үеийн ажлын мэдээлэл, хүнсний нөөцийн мэдээг өдөр бүр аймгийн шуурхай штабын хариуцлагатай жижүүрт хүргүүлэн ажилласан. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 270 мэдээ хүргүүлсэн байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны шуурхай штабын хариуцлагатай жижүүрт өдөр бүр цаг үеийн мэдээлэл мөн, Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого зохицуулалтын газарт хүнсний нөөцийн судалгааг 7 хоног бүр хүргүүлсэн байна.

Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний ажлын төлөвлөгөөний хүрээнд 2020 оны 11 дүгээр сараас эхлэн хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийн мэдээллийг сум тус бүрээр авч цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийтэд хүргэн ажилласан байна. Сайншанд болон зарим сумдад 0 зогсолт хийсэнтэй холбогдуулан хүргэлтийн үйлчилгээ хийх аж ахуйн нэгжүүдийн судалгааг гарган боломжит нөөцөд тулгуурлан аймгийн хэмжээнд нийт 141 аж ахуй нэгжид хүргэлтийн үйлчилгээ хийх зөвшөөрлийг олгож ажилласан байна.

Нийт хүнсний бүтээгдэхүүний үйлчилгээ үзүүлсэн 65 аж ахуй нэгж 19071 өрхөд 690.1 сая төгрөг, хүнсний ногооны 21 аж ахуйн нэгж 2432 өрхөд 41,7 сая төгрөг, мах, махан бүтээгдэхүүний 11 аж ахуй нэгж 2242 өрхөд 116,7 сая төгрөг, түлээ нүүрс 16 аж ахуй нэгж 1340 өрхийн 53,7 сая, эм сангийн 15 аж ахуй нэгж 2737 өрхөд 65.1 сая төгрөг нийт 967.3 сая төгрөгийн борлуулалтыг хийсэн байна.

МХГ-аас бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед аймгийн хэмжээнд үйл ажиллагааг нь хориглоогүй худалдаа үйлчилгээний 1158 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрч буй зөрчлийг арилгуулах, халдвараас урьдчилан сэргийлэх талаар зөвлөмжийг тогтмол өгч ажилласан байна.

АЗД-ын 2020 оны А/823, А/830, А/839, А/872, 2021 оны 01 дугаар захирамжуудын хүрээнд Хүнсний үйлдвэр, хадгалалт, түгээлтийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулан тус удирдамжийн дагуу 442 объектод /давхардсан тоогоор/ хяналт хийж халдвар хамгааллын дэглэм мөрдөж ажиллах тухай 962 мэдэгдэл хүргүүлсэн байна.

Дээрх хяналт шалгалтуудын явцад хязгаарлалт халдвар хамгааллын дэглэм зөрчсөн 1 аж ахуй нэгжийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоож, 2 аж ахуй нэгж, 3 иргэнд 1.5 сая төгрөгийн шийтгэвэр ногдуулж, хариуцлага тооцон ажилласан байна.

А.3 Монгол Улс хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан чанарын стандарт, олон улсын жишигт нийцсэн эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр жигд, тогтвортой, хүртээмжтэй, баталгаатай хангагдаж чадаагүй байна.

А.3.1 Аймагт болзошгүй үед хэрэгжүүлэх хүнсний нөөцийг хангах асуудлын шийдвэрлэлт оновчтой бус, нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт баталгаагүй байна.

Хүнсний тухай хуулийн 6.3-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх”, 6.5-д “нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр¹ тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга хэрэгжүүлнэ”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4.5-д “гамшгийн нөөцийг ... орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэмэгдүүлэх”, 32.1.1-д “нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх” гэж заасан байдаг.

Аймгийн Онцгой комисс нь 2020 онд “Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан баталсан байна. Уг төлөвлөгөөний 1.6-д “... гамшгийн нөхцөлд хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын төсвийг Хүнсний хангамжийн албанаас боловсруулж аймгийн Онцгой комисст танилцуулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэнэ” гэж заасан байдаг.

Тус төлөвлөгөөний дагуу хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, аймгийн хүнсний эх үүсвэрийн судалгааг гарган төлөвлөгөөнд тусгажээ.

Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, аймгийн хүнсний эх үүсвэрийн судалгаа, тооцоо

Хүснэгт №3

Д/д	Сумын нэр	Цэвэршүүлсэн усны үйлдвэр, цехийн тоо	Хүнсний худалдааны төв	Тариалангийн агуулах, элеватор, зоорь	Мал нядалгааны цэг, мах махан бүтээгдэхүүн	Талх нарийн боовны цех
1	Айраг	2	3	1	1	1
2	Алтанширээ	-	4	1	1	-
3	Даланжаргалан	1	3	1	-	-
4	Дэлгэрэх	-	3	-	1	-
5	Иххэт	-	3	1	1	-
6	Мандах	-	2	1	1	-
7	Өргөн	1	3	-	-	2
8	Сайхандулаан	-	3	1	-	-
9	Улаанбадрах	-	3	-	-	3
10	Хатанбулаг	-	3	1	1	-
11	Хөвсгөл	1	3	-	-	-
12	Эрдэнэ	-	3	-	-	-
13	Замын-Үүд	5	5	1	-	4
14	Сайншанд	5	12	12	4	11
Нийт		15	53	20	10	21

Эх сурвалж: Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө

¹ Стратегийн хүнс гэж Монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг хэлнэ

Хүснэгтээс харахад тус 8 сум цэвэршүүлсэн усны үйлдвэр, цехгүй, 5 сум зоорьгүй, 7 сум мал нядалгааны цэггүй, 9 сум талх нарийн боовны цехгүй байгаа нь гамшгийн улмаас хүн ам чанартай, аюулгүй хүнсийг хүртээмжтэй сонгон хэрэглэх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

Төлөвлөгөөний дагуу хүнсний худалдааны 53 төвүүдтэй гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлын үед шаардагдах хүнсний нөөцийн гэрээ байгуулжээ.

Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөний 1.5-д шар, улбар шар, улаан 3 зэрэгт хүнсний бодит нөөц, хоногийг тооцсон байна.

Хүнсний бодит нөөцийн судалгаа

Хүснэгт №4

Д/д	Хүнсний нэр	Аймгийн нийт бодит нөөц /тн/	Хүнсний нөөц /хоног/	Шар зэрэг /30-60 хоног/	Улбар шар зэрэг /16-29 хоног/	Улаан зэрэг /15 хүртэл хоног/
1	Малын мах	75.1	11	хангалтгүй	хангалтгүй	хангалттай
2	Гурил	152.2	26	хангалтгүй	хангалттай	хангалттай
3	Давс	10.1	35	хангалттай	хангалттай	хангалттай
4	Ундны ус	22.7	10	хангалтгүй	хангалтгүй	хангалттай
5	Хуурай сүү	7.6	7	хангалтгүй	-	-
6	Төрөл бүрийн будaa	33.0	11	хангалтгүй	хангалттай	-
7	Элсэн чихэр	12.1	6	хангалтгүй	хангалтгүй	-
8	Ургамлын тос	7.8	5	хангалтгүй	хангалтгүй	-
9	Төмс	42.8	6	хангалтгүй	хангалтгүй	-
10	Хүнсний ногоо	31.3	2	хангалтгүй	-	-

Эх сурвалж: Аймгийн ХХААГ-ын Хүнсний нөөцийн судалгаа 2021.09.27

Аймгийн ХХААГ-аас 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар гаргасан хүнсний нөөцийн судалгаанаас харахад анхны шар зэрэгт шилжих үеийн бэлэн байдлыг хангаж чадахгүй байхаар харагдаж байна.

Иймд гамшгийн үед шаардагдах зарим хүнсний бүтээгдэхүүний нөөцийн бүрдүүлэлтийг нэмэгдүүлж, хадгалалтыг сайжруулах шаардлагатай байна.

Хүнсний нөөцийг бүрдүүлэх, хяналттай байлгах үүднээс зарим аймаг Нийтлэг үйлчилгээний газартаа гамшгийн нөхцөл байдал үүсэхэд хэрэглэгдэх хүнсний нөөцийг бүрдүүлэн ажилласан сайн туршлага байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гарсан зардлын жагсаалт

Хүснэгт №5

Д/д	Захирамжийн утга	Тайлант он	Мөнгөн дүн /мянган төгрөг/
1	Гамшгаас хамгаалах сургалт	2018	6,484.0
2	Тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн	2019	1,154.5
3	Гамшгаас хамгаалах сургалт	2019	14,811.2
4	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт	2019	2,000.0
5	Эрдэнэ суманд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх	2020	9,000.0
6	Айраг суманд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх	2020	9,000.0
7	Сайншанд суманд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх	2020	9,700.0
8	Гамшгаас хамгаалах арга хэмжээ	2020	5,693.4
Нийт			57,843.1

Хүснэгтээс харахад 2018 онд 6,484.0 мянган төгрөг, 2019 онд 17,965.7 мянган төгрөг, 2020 онд 33,393.4 мянган төгрөг нийт 57,843.1 мянган төгрөгийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын арга хэмжээнд зарцуулсан байна.

ЗДНХ-өөс гаргасан нийт төсөвтэй харьцуулж тооцож үзэхэд:

- 2018 онд нийт 796,575.6 мянган төгрөг зарцуулсан бөгөөд гамшгийн зардал 0.8 хувь;
- 2019 онд нийт 592,518.1 мянган төгрөг зарцуулсан бөгөөд гамшгийн зардал 3.0 хувь;
- 2020 онд нийт 709,295.1 мянган төгрөг зарцуулсан бөгөөд гамшгийн зардал 4.7 хувьтай байна.

Иймээс СС-ын 2021 оны 61 дүгээр тушаал ЗДНХ-ийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 3.4² -т заасан аймгийн төсвийн тодорхой хувийг гамшгийн үед шаардагдах зарим хүнсний бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэхэд зарцуулах боломжтой байна

А.3.2 Хүнсний шим тэжээл, чанар, аюулгүй байдлыг шинжилж байгаа лабораторийн тоо, тоног төхөөрөмж, түүний хүчин чадал өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Итгэмжлэгдсэн төрийн, орон нутгийн болон хувийн өмчит лаборатори хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тандалт судалгаа, дээжийн шинжилгээ хийхэд оролцоно” гэж заасан.

Аймгийн Сорилтын лаборатори нь 2012 онд ЗГ-ын тогтоолоор Стандартчилал, хэмжилзүйн газраас Мэргэжлийн хяналтын газарт шилжин ирсэн. 2012 оноос хойш Чандмань Илч ОНӨХХК-ийн байранд 5 өрөөг түрээслэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Сорилтын лаборатори нь хими, хор судлал, нян судлал, ургамлын хорио цээрийн үзүүлэлтээр ААН, байгууллага, иргэдийн үйлдвэрлэж, худалдан борлуулж буй хүнсний бүтээгдэхүүн, ундны усны эх булаг, хөрс, бохир ус, тасалгааны агаар, арчдас зэрэг эрүүл мэнд, боловсролын байгууллагын үйл ажиллагаанд лабораторийн шинжилгээтэй хяналтыг хийж ажилласан байна.

² ... хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцоолж Засаг даргын нөөцөд бэлэн байршуулсан байна.

2020 онд 547 ААН иргэний нийт 3019 сорьцод 7837 үзүүлэлт тодорхойлсон ба үүнээс 528 үзүүлэлт стандартын шаардлага хангаагүй байна. Нийт үзүүлэлтийн 6.7 хувийг эзэлж байна. Үүнээс хими, хор судлалын лабораторийн шинжилгээг тодруулбал: 644 сорьцод 4028 үзүүлэлтээр хийснээс 416 үзүүлэлт стандартын шаардлага хангаагүй байгаа нь шинжилгээнд ирсэн дээжийн үзүүлэлтийн 10.3 хувийг эзэлж байна.

2020 оны хими хор судлалын лабораторийн шинжилгээ

Хүснэгт №6

Д/д	Бүтээгдэхүүний нэр, төрөл	Сорьц	Үзүүлэлт	Эерэг үзүүлэлт	Эерэг сорьцын эзлэх хувь
1	Гурилан бүтээгдэхүүн	87	261	4	1.5
2	Мах, махан бүтээгдэхүүн	149	541	18	3.3
3	Хүнсний ногоо болон жимс жимсгэнэ	94	419	3	0.7
4	Ундаа жүүс	7	14	2	14.3
5	Төвлөрсөн системийн ус	127	1466	198	13.5
6	Савласан ус	36	261	32	12.3
7	Гүний ус	91	981	154	15.7
8	Сүүн бүтээгдэхүүн	15	29	4	13.8
9	Сүү	4	17	1	5.9
10	Дарс	1	3	-	-
11	Ахуйн химийн бүтээгдэхүүн	4	4	-	-
12	Бусад	29	32	-	-
Нийт		644	4028	416	-

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2500 дээжид 5400 үзүүлэлтээр шинжилгээ хийхээр тусгасныг бүрэн хэрэгжүүлсэн ба Замын-Үүд сумын ХМХА, Говьсүмбэр аймгийн МХГ-тай лаборатори хоорондын сорилт шинжилгээ хийх гэрээ байгуулсан байна.

Дорноговь аймагт Уул уурхай, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа маш их эрчимтэй явагдаж байгаагаас хүнс болон ундны ус, бохир ус, хөрсөнд хүнд металл тодорхойлох хэрэгцээ шаардлага байдаг байна. Гэтэл хими, микро биологи талаасаа хүнсний бүтээгдэхүүний нянгийн бохирдлыг шинжилдэг, урвалж бодис байхгүйгээс хүнд металлын шинжилгээ хийдэггүй байна.

Аймгийн МХГ-ын сорилтын лабораторид шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа

Хүснэгт №7

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Зориулалт
1	Бутеротетрийн центрифуг	Хүнсний бүтээгдэхүүний тослог тодорхойлох
2	Апаеогоаг	Лаазалсан бүтээгдэхүүнд агааргүйтэн нян тодорхойлох
3	Махны шинжилгээний багаж	Мах, махан бүтээгдэхүүнд 5 төрлийн үзүүлэлт тодорхойлох
4	Микотоксины агууламжийг тодорхойлох оношлуур	Хор судлалын шинжилгээнд ашиглах
5	Антибиотикийн үлдэгдлийн оношлуур	Хор судлалын шинжилгээнд ашиглах
6	Автомат пипетка 100-1000 мкл	Хор судлалын шинжилгээнд ашиглах
7	Ус нэрэгч	Сорилт шинжилгээнд ашиглах
8	Уураг тодорхойлогч	Сорилт шинжилгээнд ашиглах
9	Атом шингээлтийн спектрофотометр	Сорилт шинжилгээнд ашиглах
10	Электрон микрометр	Нийлэг уутны зузаан хэмжих
11	Шил сав хадгалах шүүгээ	Ариутгасан шил савыг хадгалах
12	Бодис хадгалах агаар сорогчтой, хөргөгч	Бодис урвалжийг хадгалах
13	Жингийн ширээ /разеткай/	Аналитик жинг суурилуулах зориулалттай.
14	Бусад /бодис урвалж, шил сав/	Сорилт шинжилгээнд ашиглах

Цаашид аймгийн нийт хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, сорилт шинжилгээг гүйцэтгэх хүчин чадалтай сорилтын лабораторийн барилга барих, хүнс болон ундны ус, бохир ус, хөрсөнд хүнд металл тодорхойлох атом шингээлтийн багаж оношлуур, лабораторийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр хүчин чадлыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Замын-Үүд сумын Сорилтын лаборатори нь Химийн хор судлал, ургамлын, нян судлалын шинжилгээгээр 2019 онд 6793 сорьцод 45893 үзүүлэлт тодорхойлсноос 61 сорьц үзүүлэлт стандартын шаардлага хангаагүй, 2020 онд нийт 21185 сорьцод 119429 үзүүлэлт тодорхойлсноос 98 сорьц үзүүлэлт стандартын шаардлага хангаагүй байна.

Замын-Үүд сумын хилээр нэвтэрч буй хүнсний бараа бүтээгдэхүүний 10 хүртэлх хувийг сумын Хилийн мэргэжлийн хяналтын албаны Сорил лабораторид шинжилдэг харин бусад шинжилгээг ХАБҮЛЛ шинжилдэг байна.

Сорилтын лабораторийн стандартын шаардлага хангаагүй гарсан бүтээгдэхүүн
Тухайлбал: 2020 онд

- Лийрнээс жимсний цахлай;
- Хашнаас цацаг далавчтан;
- Байцаанаас байцааны бөөс;
- Цагаан будаанаас шөвгөр хошуут цох илэрсэн байна.

Сорилтын лаборатори нь эрхлэгч, чанарын менежер-1, хими хор судлалын шинжээч-3, ургамлын хорио цээрийн шинжээч-4, нян судлалын шинжээч-2 нийт 10 орон тоотой байна.


2020 оноос сорилт шинжилгээнд хамрагдаж буй дээжийн тоо хэмжээ тасралтгүй нэмэгдсэн нь 1 шинжээчид оногдох ажлын ачаалал 4 дахин нэмэгдсэн мөн тус лабораторийн шинжээч нар сорилт шинжилгээний ажлын зэрэгцээ лаборант, үйлчлэгч, дээж бүртгэгч шинжээч, архивын материалыг бүрдүүлэгч, шил сав угаагчийн ажлыг давхар гүйцэтгэхийн зэрэгцээ хил хяналтын онцлогоос шалтгаалан хортой нөхцөлд байнгын өдөр бүр 3-4 цаг илүү ажиллаж нэг шинжээчид ноогдох ажлын ачаалал нэмэгдсэн байна.

Тус лаборатори нь 2020 оны 08 дугаар сараас МТЗ-ын өмч бөгөөд УБТЗ түрээсээр ашиглаж буй ачаа бараа хүлээж авах төлбөр тооцоо хийх зориулалтаар баригдсан лабораторийн зориулалтын бус байранд сорилт шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэж байна. Түрээслэгч тал хана тааз цоолох, барилга байгууламжийг өөрчлөх зэргийг зөвшөөрөөгүйгээс Сорилтын лабораторийн татах шүүгээ холболт хийгдээгүй, хими хор судлалын лабораторийн угаалтуур нь шугам сүлжээнд холбогдоогүй байна. Мөн сорилт шинжилгээнд ашиглагдаж байгаа зарим бодис урвалж хадгалах горимоороо хадгалагддаггүй эрсдэл байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд суманд Хилийн мэргэжлийн хяналтын албаны “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах лабораторийн барилга” баригдаж байгаа ба уг лаборатори ашиглалтад орсноор одоо ажиллаж буй лабораторийн хүчин чадал 25 хувиар нэмэгдэж, хүнс, ургамал, эрүүл ахуйн аюулгүй байдалд чанар стандартын өндөр түвшинд хяналт тавих боломжтой төдийгүй хөдөө аж ахуйн гаралтай болон хүнсний бүтээгдэхүүнийг олон улсад саадгүй худалдаалах боломж бүрдэх юм байна.

Шинэ лабораторийн 38 нэр төрлийн 103710 долларын өртөг бүхий оффис болон шинжилгээний иж бүрэн тавилга, лабораторийн тоног төхөөрөмж, шинжилгээний багаж хэрэгсэл хүлээн авсан байна.

Зураг № 1



Зураг №2



Аймгийн МХГ-ын лаборатори нь тоног төхөөрөмжийн хувьд дутагдалтай байгаа бол Хилийн мэргэжлийн хяналтын албаны лабораторийн ажлын байр шаардлага хангахгүй байна.

Иймд МХГ-ын лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах, Хилийн мэргэжлийн хяналтын албаны лабораторийн барилгыг яаралтай ашиглалтад оруулах шаардлагатай байна.

А.3.3 Дорноговь аймагт хүнсний дотоодын үйлдвэрлэл болон импортын зохистой харьцаа алдагдсан, хүнсний хангамжийн бодлого үр дүнгүй байна.

Аудитын явцад Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалаар батлагдсан “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай” жишсэн дундаж хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ болон аймгийн “Статистикийн эмхэтгэл 2020”-аас дотоодын үйлдвэрлэлийн хэмжээтэй харьцуулан аймгийн хүнсний хангамжийн хувийг 2019, 2020 онуудаар тооцож үзлээ.

Аймгийн дотоодын үйлдвэрлэлийн хүнсний хангамжийн тооцоолол

Хүснэгт №8

Д/д	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний төрөл	1 хүний хоногийн норм /кг/	1 хүний жилийн хэрэгцээ /кг/	ЖДХА-ын жилийн хэрэгцээ /тн/		Дотоодын үйлдвэрлэл /тн/		Хангамжийн хувь**	
				2019 он ЖХА 50954	2020 он ЖХА 51976	2019 он	2020 он	2019 он	2020 он
А	Б	В	Г=В*365	Д=Г*ЖХА		Е		Ё=Е/Д*100	
1	Мах	0.120	43.8	2,231.8	2,276.5	29.4	36.1	1.3	1.6
2	Сүү	0.160	58.4	2,975.7	3,035.4	50.0	42.9	1.7	1.4
3	Гурилан бүтээгдэхүүн	0.180	65.7	3,347.7	3,414.8	318.6	429.1	9.5	12.6
4	Төмс	0.120	43.8	2,231.8	2,276.5	85.8	87.0	3.8	3.8
5	Хүнсний ногоо	0.260	94.9	4,835.5	4,932.5	223.5	191.6	4.6	3.9
6	Жимс, жимсгэнэ	0.200	73.0	3,719.6	3,794.2	147.3	73.8	4.0	1.9
7	Цэцгийн тос	0.010	3.7	186.0	189.7	2.6	2.6	1.4	1.2
Нийт								3.8	3.8

**Хүнсний хангамжийн хувь гэж улсын хэмжээний тухайн хүнсний бүтээгдэхүүний жилийн нийт нөөцийг жишсэн хүн амын хүнсний жилийн хэрэгцээнд харьцуулж тодорхойлсныг хэлнэ.

Хүснэгтээс харахад мах, сүү, жимс жимсгэнэ, цөцгийн тос зэрэг нь дотоодын хэрэгцээний 2 хүртэлх хувь, төмс, хүнсний ногоо 4 хүртэлх хувь, гурилан бүтээгдэхүүн 13 хүртэлх хувь, нийт дунджаар 4 хүртэлх хувийг хангаж байгаа нь УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.2.2-т “Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна” гэж заасан гэтэл аймгийн хэмжээнд дотоодын үйлдвэрлэл бага буюу 3.8 хувьтай байна.

Дорноговь аймаг хүнсний хэрэгцээгээ дотоодод үйлдвэрлэх болон импортлох хэлбэрээр бүрдүүлж байна.

Манай аймаг нь БНХАУ-тай хиллэдэг учир хүнсний импортын бүтээгдэхүүн давамгайлж байгаагаас хүнсний үйлдвэрлэл эрхлэх боломж хомс, иргэдийн санал санаачилга бага байна.

Аймгийн хэмжээнд мах боловсруулах 2 үйлдвэр, 6 цех үйл ажиллагаа явуулж байгаа ч жилийн 3, 4, 5 саруудад махны хомсдол үүсдэг асуудал байсаар байна. Учир нь тухайн хугацаанд малчид малын махаа зардаггүй, мөн махны үйлдвэр нь дотооддоо борлуулалт хийхгүйгээр Улаанбаатар хот болон уул уурхай компаниудад бүтээгдэхүүнээ нийлүүлэх сонирхолтой байдаг байна.

Манай аймагт гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн болох гурилын үйлдвэр байхгүй байна.

Иймээс “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-д тусгасан эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн амыг жигд хүртээмжтэй хангах, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, импорт орлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих, үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, будаа, гурилын үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх шаардлагатай байна.

А.3.4 Бүтээгдэхүүнийг импортлох болон дотоодод үйлдвэрлэж эхлэхээс хэрэглэгчдэд хүрэх хүртэлх хугацааны бүх үе шатанд чанарын удирдлага, хяналт үр дүнгүй байна.

Хүнсний тухай хуулиар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлагад 10.1.1-д “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах”, 10.1.2-д “стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх”, 10.1.5-д “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд мэргэжлийн, эсхүл мэргэшсэн хүний нөөцтэй байх”, 12.1-д “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна” гэж заасан байдаг.

Аудитын явцад аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байцаагч, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтний хамт Сайншанд сумын цэвэр усны үйлдвэр, талхан цех, хиаман цех, 4 хүнсний дэлгүүрийг түүвэрлэн Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар хэрэгжилтийг үзэхэд стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагад нийцэж байсан.

Харин дараах шаардлагыг бүрэн хангасан газар байхгүй байна. Үүнд:

- Цар тахалтай холбоотойгоор 2021 онд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг ажилтныг эрүүл мэндийн үзлэгт оруулаагүй, ажилчин албан хаагчид ажлын байранд ажлын хувцас өмсөж хэвшээгүй, цэвэрлэгээ үйлчилгээ хангалтгүй, агуулахын эмх цэгц муу зэрэг нийтлэг зөрчилтэй байв.
- Талхан цех, усны үйлдвэр бүтээгдэхүүний шошгонд цувралын дугаар байхгүй, гарал үүсэл нь тодорхойгүй жижиглэн савласан бүтээгдэхүүнд /масло, печень, үзэм, самар/ дахин хаяг, шошгожуулалт хийгээгүй.

Зураг № 3



Зураг №4



Хүнсний 3 дэлгүүрт хэрэглэж дуусах хүнсний бүтээгдэхүүний хугацаа дууссан 10 нэр төрлийн 66 уут боорцог, слава ургамлын тос 1 ш, шокотель 1 ш, кимчи 3 ш, торт сицилия 3 ш, мишка косалапы 5 ш, пирог 6 ш, сир сливочны 6 ш, вафли 10 ш бүтээгдэхүүнийг хураасан.

Зураг №5



Зураг № 6



Аудитын явцад МХГ-ын байцаагчтай ярилцлага хийхэд орон нутаг, сумдад дараах нийтлэг зөрчлүүд байсаар байна. Үүнд:

- Нэг агуулахтай, зориулалтын төрөлжсөн агуулахгүй;
- Хөдөө сумдад хүнсийг зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгслээр тээвэрлэдэггүй;
- Хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах нөхцөлд хадгалаагүйгээс хүнсний аюулгүй байдал алдагдах, эрсдэл үүсэх магадлал хэвээр байна.

Хиаман цехийн үйлдвэрлэлийн процесс нь мал эмнэлгийн байгууллагаас олгосон гарал үүслийн бичигтэй мал амьтдыг хүлээн авч бүртгэл хөтлөн, сэргүүрийн өрөөнд хадгалан, мэргэшсэн жор баригч, туслах ажилтнууд бүтээгдэхүүний үйлдвэрлэж хүнсний зориулалтын сав, баглаа боодол шошгожуулалт хийж, мах махан бүтээгдэхүүнийг хөлдөөх, хадгалах зориулалтын өрөөнд хадгалан, бүтээгдэхүүнийг хөргүүртэй тээврийн хэрэгслээр тээвэрлэж, өөрийн нэрийн дэлгүүр болон бусад дэлгүүрт худалдаалдаг байна. Бүтээгдэхүүнийхээ дээжнээс 6 сард 1 удаа шинжилгээ өгч шинжлүүлэг байна.

Усны цехийн хувьд анхаарах асуудал нь ус зөөлрүүлэгч, шүүгчийг зааврын дагуу хугацаанд нь сольж сэргээсэн бүртгэл хөтлөөгүй, үйлдвэрлэлд ашиглах сав, баглаа боодлыг зааврын дагуу угааж цэвэрлэх зориулалтын тоног төхөөрөмжгүй, үйлдвэрлэлийн өрөө тасалгааг технологийн дамжлагын дагуу түүхий эд хүлээн авахаас эхлээд эцсийн бүтээгдэхүүн гаргах хүртэл нэг чиглэлийн урсгалтай байхаар зохион байгуулаагүй байсан.

А.3.5 Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт “Шилэн хяналтын систем”-ийг нэвтрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

ХБАБХТ хуулийн 4.1.6-д “хүнсний сүлжээ” гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг хэлнэ” гэж заасан.

ХХААГ нь аймгийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хүнсний худалдааны төв, хоол үйлдвэрлэгч нарын нэгдсэн бүртгэлийг хөтөлдөг байна.

Харин МХГ нь Шилэн хяналтын цахим системийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нь хяналт шалгалттай холбоотой 90 төрлийн маягтын дагуу статистик тайланг гаргадаг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эрсдэлийн төлөв байдлын дүн шинжилгээг нээлттэй харах, иргэд олон нийтэд үйл ажиллагаагаа хүргэх, хийсэн ажлаа нэгтгэж дүгнэхэд ач холбогдолтой шийдэл болсон байна.

А.3.6 Орон нутгийн экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх талаар хэрэгжүүлсэн хөтөлбөр үр дүнтэй байна.

Хүнсний тухай хуулийн 8.1.1-д “стратегийн хүнсний үйлдвэрлэл”, 8.1.3-д “хүүхдийн хоол тэжээл болон органик хүнсний үйлдвэрлэл”, 8.1.4-д “хүний бие махбодийг бүхэлд нь, эсхүл тодорхой эрхтний үйл ажиллагааг дэмжих шаардлагатай бодис, илчлэгийг нөхөх үйлчилгээ бүхий биологийн идэвхт бодис, баяжуулсан, ашигтай бичил биетэн агуулсан зохицуулах үйлчилгээтэй хүнсний үйлдвэрлэл”, 8.1.7-д “дотоодын түүхий эд ашиглан шинэ технологиор импортыг орлох хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн зэрэг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа

эрхлэхэд төрөөс хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд дэмжлэг, урамшуулал үзүүлж болно” гэж заасан байдаг.

"Орон нутгийн экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх" дэд хөтөлбөрийг аймгийн ИТХТ-ийн 2018 оны 66 дугаар тогтоолоор баталсан байна.

ЭМС-ийн 2017 оны А/74 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад заасан хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодисын хэмжээг ҮСХ-оос гаргасан жишсэн дундаж нэг хүний хүнснээс авч буй бодит илчлэгийн шим тэжээлийн хэмжээтэй /хөдөө/ харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

Нэг хүний хүнснээс авч буй бодит илчлэг шим тэжээл

Хүснэгт №9

Д/д	Нэр төрөл	Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг	Сэрүүний улиралд	Зуны улиралд
1	Илчлэг, ккал	2400	3,429.2	3,629.6
2	Уураг, гр	90	168.9	177.7
3	Тос, гр	67	93.9	102.6
4	Нүүрс ус, гр	360	480.9	503.1

Эх сурвалж: www.1212.mn Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Хүнс нь үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодис болон бичил тэжээлийн бодисуудаас бүрддэг. Үндсэн шимт бодис гэдэгт уураг, тос, нүүрс ус хамаардаг байна.

Хөтөлбөрийн хүрээнд 2017-2020 онд орон нутгийн өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд мал аж ахуй, газар тариалан, түүхий эд боловсруулах үйлдвэр шинээр байгуулах болон өргөжүүлэхэд “Сум хөгжүүлэх сан”-аас 118 төсөлд 1.6 тэрбум төгрөг, “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан”-гаас 5 төсөлд 643.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 3%-иар өссөн байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжүүд нь нийт 224.6 мянган литр сүү, сүүн бүтээгдэхүүн, 178.3 тн мах, махан болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн, газар тариалангийн 20 нэр төрлийн 29460 гаруй шил нөөшилсөн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 10.1%-аар өссөн байна.

Шинээр морин шошны 2 сорт, бөөрөн шошны 2 сорт, хомигуа, амтат гуаны 2 сорт арвайтай цай, тэмээн тавхай нэртэй цэвэр үхрийн сүүний ааруул, Шинжааны хар хальст зэрэг гуатан ургамлыг шинээр туршин тариалж, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлсэн байна.

А.3.7 Хүнсний худалдаанд зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хэрэглэхэд тавих хяналтын тогтолцоог илүү сайжруулах, иргэд аж ахуй нэгжид энэ талаарх мэдлэгийг төлөвшүүлэх шаардлагатай байна.

Сав баглаа боодлын талаар Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.1³-д, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.1.10⁴-д "Сав, баглаа боодол" үндэсний хөтөлбөрийн 3 дугаар зүйл, *Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2013 оны А/46/115 дугаар тушаалаар баталсан "Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам"-ын 5.5⁵-д тус тус заасан байдаг.*

"Сав, баглаа боодол" үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын А/463 дугаар захирамжаар баталжээ.

Сав, баглаа боодол хөтөлбөрийг сурталчлан зохион байгуулах ажлын хүрээнд АЗДТГ, МХГ, СХЗХ, БСУГ, ЭМГ, сумдын ЗДТГ, ТББ-тай хамтран хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, сумдын мэргэжилтэн, иргэдэд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй савны сургалт, сурталчилгаа, олон улсын хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээний тухай брошур гарын авлага тараан, төсөл хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамруулах, хуулийн талаар сургалт сурталчилгаа хийж мэдээ мэдээлэл солилцох, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэрэг ажлуудыг хамтран зохион байгуулан ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/470 дугаар захирамжаар "Хөх сав, канистргүй аймаг, сум, баг, өрх" аяныг зарласан. Аяны хүрээнд орон нутгийн 22 сургууль, 37 цэцэрлэг, нэгдсэн эмнэлэг 2, сумын эрүүл мэндийн төв 14, сум дундын 1, цэргийн эмнэлэг 2, хувийн ортой 5 эмнэлгийн гал тогоонд ашиглагдаж байсан зориулалтын бус хуванцар савыг хэрэглээнээс халж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн зориулалтын савыг 100% хэрэглээнд нэвтрүүлсэн байна.

Аймгийн нийт өрхийн 26% нь хөх савыг хэрэглээнээс халаад байна гэсэн тоон үзүүлэлт гарсан байна.

Айл өрхийн ундны усны хуванцар савыг стандартын төмөр саваар солих "БРЭНД" ажлыг өрнүүлэн 5 багийн 175 өрх ундны усны саваа шинэчилсэн байна. Мөн 5 сумын Засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн зөвлөлтэй хамтран сумдад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулан зориулалтын усны савыг ард иргэдэд түгээх гэрээт борлуулагч болгон батламж гардуулсан байна.

³ хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийсэн хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савласан байна

⁴ хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх үе шатанд хэрэглэх, дэвшилтэт технологийг нутагшуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжих

⁵ Хүнсний хяналтын байгууллага нь Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хүрээнд энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай мэдээллээр төрийн, төрийн бус байгууллага болон хэрэглэгчдийг хангаж ажиллана.

Мөн тус аяны хүрээнд зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, худалдаа, үйлчилгээ эрхлэгч ААНБ, иргэдэд олон улсын тэмдэг, тэмдэглэгээний таних тэмдэг, зориулалтын сав, баглаа боодол түүний ач холбогдлын талаарх сургалт, сурталчилгаа, мэдээллийг 14 суманд зохион байгуулж 240 гаруй иргэн хамрагдсан. Мандах сумын “Говь трайн” ХХК нь гялгар уутыг хэрэглээнээс халж даавуун уутыг, Улаанбадрах сумын худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн 0,4% нь цаасан уутыг, Иххэт сумын худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн 0,2% нь цаасан болон даавуун уутыг хэрэглээ, худалдаанд нэвтрүүлж хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллажээ.

Мөн дээрх хөтөлбөрийн хүрээнд Сайншанд сумын Засаг даргын 2020 оны “Аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн дагуу 12 хүнсний худалдааны төвүүдэд хүнсний аюулгүй байдал, зориулалтын бус сав баглаа боодлын хэрэглээг бууруулах чиглэлээр хяналт тавьсан байна. Хяналт шалгалтаар тус захууд хүнсний зориулалтын бус сав баглаа боодлыг хэрэглэхээс татгалзан зөвшөөрөгдсөн 0.33 мм-с илүү зузаантай гялгар уут болон цаасан уутыг хэрэглэж хэвшсэн байна.

Мэргэжлийн хяналтын газар нь хүнсний аюулгүй байдлын чиглэлээр дэлгүүр худалдааны төвүүдэд хийдэг “Худалдаалах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-т нэг бүлэг “Бүтээгдэхүүний шошго, сав баглаа боодолд тавигдах шаардлага” бүхий 10 асуулт багтсан байна. МХГ-ын 2020 оны хяналт шалгалтын баримтаас авч үзвэл тухайн асуулгын хүрээнд 37 алдаа зөрчилтэй аж ахуй нэгж, дэлгүүрээс сав баглаа боодлын хувьд хамгийн их зөрчил гардаг дарааллаар доорх хүснэгтэд эрэмбэлэн харууллаа.

Хяналт шалгалтын хуудсаар илэрсэн нийтлэг зөрчлийн жагсаалт

Хүснэгт №10

№	Хяналт шалгалтын асуултууд	Алдаа зөрчлийн тоо
1	Хадгалах болон хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн хүнсний эд, бүтээгдэхүүний худалдаанд гаргаагүй	11
2	Жижиглэн савласан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод ХБАБХТХ-ийн 12.41-д заасан мэдээллээс гадна жижиглэн савласан он, сар, өдрийг бичсэн	10
3	Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний шошгын мэдээлэл шаардлага хангасан	9
4	Буруу шошголсон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн худалдаагүй	3
5	Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн шошгод агуулагдах мэдээлэл монгол, орос, англи хэлний аль нэг дээр бичигдсэн	2
6	Баяжуулсан хүнсний шошгод тэмдэг, тэмдэглэгээ тавигдсан	1
7	Хүнсний зориулалтын сав, баглаа боодолд савласан	1
Нийт дүн		37

Дээрх сав баглаа, шошгын зөрчилтэй бүтээгдэхүүнүүдийг улсын байцаагчийн акт үйлдэн 150 нэр төрлийн 1395 ширхэг 3.0 сая төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүн хурааж, сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлэн устгуулж гарч болзошгүй эрсдэлээс сэргийлж ажилласан байна.

Аудитын явцад аудитын баг МХГ-ын улсын байцаагч, АЗТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэнтэй хамтран хяналт шалгалт хийхэд дээрх сав баглаа боодол, хаяг шошгожуулалттай холбоотой зөрчил шалгалтад хамрагдсан хүнсний дэлгүүрүүдэд илэрч байгаа нь анхаарал татахуйц байна.

Иймд зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэхэд тавих хяналтын тогтолцоог илүү сайжруулах, иргэд аж ахуй нэгжид энэ талаарх мэдлэгийг төлөвшүүлэх шаардлагатайг харуулж байна.

3.8 Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар сургалтыг зохион байгуулж байгаа боловч үр дүн муутай байна.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.1.18-д “хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлэх” гэж заасан байдаг.

Орон нутгийн хэмжээнд дээрх бодлоготой уялдуулан Аймгийн засаг дарга холбогдох байгууллагын удирдах албан тушаалтнуудтай байгуулсан гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусган оруулсан байна.

“Давсны хэрэглээгээ бууруулъя” үндэсний стратеги, “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөр, “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрүүдийн хүрээд аймгийн хэмжээнд иргэдэд мэдээлэл сургалт өгөх чиглэлээр ЭМГ, МХГ, ХХААГ, ЗДТГ жил бүр хамтран сургалт сурталчилгаа, дэмжлэгт хяналт шалгалт явуулсан байна.

ЭМГ-аас “Давсны хэрэглээгээ бууруулъя” үндэсний стратегийн хүрээнд жил бүр уриа дэвшүүлж, удирдамж батлуулан сургалт сурталчилгааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна. Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд давхардсан тоогоор 60-аад байгууллагуудад албан тоот, удирдамж хүргүүлэн, арга зүйн зөвлөгөө өгч ажиллажээ.

2018-2020 онуудад 1017 өдөрлөг нээлттэй хаалганы өдөр, аян, хоол болон хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн, өртөөчилсөн сургалт, сурталчилгаа хийж давхардсан тоогоор 52661 хүн хамруулан 17862 ширхэг гарын авлага тараах материал тараан, оюутан сурагчдын дунд эссэ бичлэгийн уралдаан зэргийг зохион байгуулсан байна.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран “Давсны хэрэглээг хязгаарлая” хэвлэлийн бага хурал, “Эмч зөвлөж байна” булан, цаг үеийн мэдээлэл, видео бичлэг, үгэн болон зурган мэдээлэл, байгууллагын вэбсайтаар дамжуулан мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэж, 21 эрүүл мэндийн байгууллагын 43 вэбсайтаар 57 төрлийн мэдээллийг цахим сайтуудаар дамжуулан иргэдэд хүргэж, 10501 хандалтыг авсан.

Мөн иргэдэд эрүүл зохистой хооллолтын үр ашиг, хооллолтоор дамжуулан эрүүлжих аргын талаар иргэдэд тасралтгүй мэдээлэл хүргэж байх зорилгоор 57 сайн дурын ажилтанд мэдээлэл өгч түүгээр дамжуулан 1425 иргэнд мэдээлэл сурталчилгааг түгээсэн тоон мэдээ гаргасан байна.

Хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагууд, хүнс нийлүүлэгч аж ахуй нэгж, сургууль цэцэрлэгт 17 удаагийн дэмжлэгт хяналтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран ЭМГ-аас хийсэн байна.

Хэдийгээр хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх талаар арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч 2018-2020 онд Аймгийн ЭМГ-аас гаргасан хоол тэжээлтэй холбоотойгоор үүсэх өвчлөл, хэвтэн эмчлүүлэгчдийн судалгаагаар хоол боловсруулах эрхтэн тогтолцооны нийт өвчлөл жил ирэх тутам нэмэгдсэн байна.

Бүртгэгдсэн өвчлөлийн судалгаа

График №1



**Хэвтэн эмчлүүлсэн хүний судалгаа**

График №2



Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөлөөр хэвтэн эмчлүүлэгчдийн тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа нь иргэд өөрсдийнхөө аюулгүй байдлын төлөө хоол хүнсээ сонгохдоо хариуцлагагүй ханддагтай холбоотой байна.

Өөрөөр хэлбэл, хүнсний аюулгүй байдал нь иргэдийн худалдан авалт, зохистой хэрэглээтэй шууд холбоотой байна. Мөн хэрэглэгчид хүнсний бүтээгдэхүүнээ зөв сонгон авч, зөв хадгалж чадахгүй, хүнсний аюулгүй байдлын талаарх мэдлэг муу байна.

Иймд иргэдэд хүнсний аюулгүй байдал, хоол, хүнсний талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулах, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх, Хүүхдэд багаас нь хүнсээ хэрхэн сонгох, зөв хооллолт, зөв дадлыг хэвшүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ Б. Дэд хөтөлбөр тус бүрээр төсөв баталдаггүйгээс төсвийн зарцуулалт, үр дүнг тодорхойлох боломжгүй байна.

Б.1 “Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ”-д нийт дүнгээр төсвийг төлөвлөсөн нь дэд хөтөлбөр бүрийн үр дүнг тооцох боломжгүй байна.

Б.1.1 Хөтөлбөрт суурилан төсвийг төлөвлөөгүй байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 1 дүгээр хавсралтын 7.5.6-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулж, ... төсвийн захирагчийн нэр, хөтөлбөрийн нэр, тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт, тухайн жилд хүрэх тоо хэмжээний үзүүлэлт; зарцуулах төсөв”-ийг хавсралтад тусгана” гэж заасан байна.

2017-2020 онд хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр Сум хөгжүүлэх сангаас 1,127.0 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас хөнгөлөлттэй төслийн зээлд мах боловсруулах үйлдвэрийн өргөтгөл, ургамлын цай, сүүний үнээний фермерийн өргөтгөл, тоног төхөөрөмж авах зэрэг 5 төсөлд 406.1 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

Сум хөгжүүлэх сангаас олгогдсон зээл

						Хүснэгт №11
№	Үйл ажиллагааны төрөл	Зээлийн хэмжээ сая.төг	Нийт дүн	Үйл ажиллагаатай хэвийн	Үйл ажиллагаа явагдахгүй	Зээлийг зориулалт бусаар ашигласан
1	Хоол үйлдвэрлэл	62.0	5	1	4	-
2	Хүнсний ногоо, жимс	299.0	28	15	10	3
3	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдан борлуулах	309.0	18	12	5	1
4	Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, худалдан борлуулах	190.5	12	10	1	1
5	Гурилан бүтээгдэхүүн, үйлдвэрлэл	216.5	16	15	1	-
6	Цэвэр ус үйлдвэрлэл	25.0	1	1	-	-
7	Хүнсний худалдаа	25.0	1	1	-	-
Нийт дүн		1,127.0	81	55	21	5

Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт 2018-2020 онуудад хэрэгжүүлэхээр дараах дэд хөтөлбөрүүдийг баталжээ. Үүнд:

- “Орон нутгийн экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх” /2018-2021/;
- “Хүнсний ногоо” /2018-2022/;
- “Жимс, жимсгэнэ” /2018-2022/;
- “Дорноговийн хонины мах” /2016-2020/;
- “Малын эрүүл мэнд”

Аймгийн төсөвт “Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний зардалд 2019 онд 300.0 төгрөг, 2020 онд 400.0 сая төгрөгийн төсөв баталжээ.

Аймгийн “Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардал”-ын төсвийн төсөлд хавсралтын дагуу дэд хөтөлбөр бүрээр тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт, тухайн жилд хүрэх тоо хэмжээний үзүүлэлт; зарцуулах төсвийг тооцоогүй байна.

Аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд баталсан төсвийн 2019, 2020 оны зарцуулалтыг үзэхэд хүнсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрүүдийн хүрээнд дараах зардлууд зарцуулагдсан байна.

**Хүнсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрүүдийг
хэрэгжүүлэхэд гарсан зардал**

Хүснэгт №12

№	Утга	Он	Зарцуулсан төсөв /сая төгрөг/
1	Мал эмнэлгийн гэрчилгээний цахим систем	2020	12.0
2	Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаа	2020	1.6
3	Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаа	2019	3.9
Нийт дүн			17.5

Нийт хөтөлбөр арга хэмжээний зардлын 0.01-0.03 хувийг хүнсний чиглэлийн хөтөлбөрүүдэд зарцуулсан байна. Аймгийн дэд хөтөлбөр бүрээр зардлын төсвийг төлөвлөөгүйгээс хөтөлбөр арга хэмжээ тус бүрээр зарцуулсан төсвийг тодорхойлох боломжгүй байна.

Иймд дэд хөтөлбөр бүрээр тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт, тухайн жилд хүрэх тоо хэмжээний үзүүлэлт, зарцуулах төсвийг хавсралтын дагуу гаргаж байх шаардлагатай байна.

Б.1.2 Зорилт, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөхдөө хэрэгцээ, шаардлага, үр ашгаар эрэмбэлээгүй байна.

Төсвийн тухай хууль 32.2.11-д төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга гэж заасан байна.

Аймгийн төсвийн төсөлд дэд хөтөлбөрүүдийг тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг тодорхойлоогүйгээс шаардлага гарсан тухайн цаг хугацаанд нь төсвийг хуваарилж, зарцуулдаг байна. Энэ нь эхэн үед хэрэгжих хөтөлбөрүүдийг санхүүжүүлж, оны сүүлээр хэрэгжих хөтөлбөр арга хэмжээ санхүүжилтгүй болох эрсдэл үүсгэж байна.

Б.2.1 Хөтөлбөр арга хэмжээний зардлын төсвийн төлөвлөлтийн хавсралтыг гаргаагүй тул хөтөлбөр бүрээр зарцуулалтыг тодорхойлох боломжгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэж заасан байдаг.

2018-2020 онд сум хөгжүүлэх сангаас олгосон нийт 81 төсөлд олгосон зээлийн 5 нь зориулалт бусаар ашигласан, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон 8 төсөлд олгосон зээл нь зориулалтын дагуу зарцуулагдаж, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна.

АЗД-ын 2020 оны А/579 дүгээр захирамжаар МЭГ-т 12.0 сая төгрөгийн мал эмнэлгийн гэрчилгээний цахим системд ашиглах уншигч, хэвлэх төхөөрөмжийн зардлыг шийдвэрлэж өгсөн байна.

Орон нутгийн хүнс, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлуулах зорилгоор АЗД-ын захирамжаар жил бүр “Намрын ногоо өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулдаг байна. 2019-2020 онд 14 сумын 200 гаруй иргэн, аж ахуйн нэгж, хоршоо, нөхөрлөл оролцож, 400 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг сурталчлан нийт 188.0 гаруй сая төгрөгийн борлуулалтыг хийсэн.

Б.2.2 Төсвийн гүйцэтгэлд тавих хяналт хийгдээгүй байна.

Төсвийн тухай хуульд бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах гэсэн үүрэг хүлээнэ” гэж заасан байна.

Гэтэл аймгийн хүнсний чиглэлийн дэд хөтөлбөр тус бүрээр төсвийг батлаагүйгээс гүйцэтгэлд тавих хяналт хийх боломжгүй байна.

ДҮГНЭЛТ

УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын тайлан ирүүлээгүй, УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг дангаараа тайлагнадаггүй гэсэн тайлбар өгч, хэрэгжилтийг ирүүлээгүй тул үнэлэх боломжгүй байв.

“Сав, баглаа боодол”, “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгаас дэд хөтөлбөрийг боловсруулж батлуулаагүй, “Хүнсний ногоо”, “Жимс жимсгэнэ”, “Орон нутгийн экологийн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх” аймгийн дэд хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн зарим заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

АЗДҮАХ, дэд хөтөлбөрүүдийн хувьд хэрэгжилтийг зөвхөн төрийн байгууллагууд л ханган ажиллахаар тусгаж өгсөн байгаа нь төрийн бус байгууллагууд хүнсний аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллах талаарх бодлого дутагдаж, ажлын уялдаа холбоог хэрхэн хангах талаар тодорхой тусгаагүй байна.

Сумдад ажиллаж байгаа хүнс хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн нь хяналт шалгалт хийх байцаагчийн эрхгүй тул хяналт хийхэд хүндрэл учирдаг, МХГ-ын суманд жилд нэг удаа төлөвлөгөөт хяналт хийдэг нь тухайн суманд хүнсний аюулгүй байдлын хяналтын байнгын тогтолцоо болж чадахгүй байна.

Аймгийн хэмжээнд 2018-2020 онд нийтийг хамарсан хордлого, халдварын тохиолдол бүртгэгдээгүй, ЭМГ-т хүнсээр дамжуулан хүний эрүүл мэнд хохирсон талаарх өргөдөл гомдол ирээгүй байна.

Хүнсний худалдааны төвүүдтэй гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлын үед шаардагдах хүнсний нөөцийн гэрээ байгуулсан ч найдвартай, баталгаатай аюулгүйн нөөц болж чадахгүй байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2018-2020 онд нийт 57,843.1 мянган төгрөгийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын арга хэмжээнд зарцуулсан байна.

МХГ-ын Сорилтын лаборатори нь хүнс болон ундны ус, бохир ус, хөрсөнд хүнд металл тодорхойлох шинжилгээ хийдэггүй байна.

Замын-Үүд сумын хилээр нэвтэрч буй хүнсний бараа бүтээгдэхүүний 10 хүртэлх хувийг сумын Хилийн мэргэжлийн хяналтын албаны Сорил лабораторид шинжилдэг харин бусад шинжилгээг ХАБҮЛЛ шинжилдэг байна.

Замын-Үүд сумын ХМХА-ны лаборатори нь зориулалтын бус түрээсийн байранд байгаагаас Сорилтын лабораторийн татах шүүгээ холболт хийгдээгүй, хими хор судлалын лабораторийн угаалтуур нь шугам сүлжээнд холбогдоогүй, сорилт шинжилгээнд ашиглагдаж байгаа зарим бодис урвалж хадгалах горимоороо хадгалагддаггүй эрсдэл байна.

Худалдааны төвүүдэд зориулалтын төрөлжсөн агуулахгүй, хөргүүртэй тээврийн хэрэгсэлгүй, хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах нөхцөлд хадгалаагүй зэрэг зөрчлүүд давтагдсаар байна.

Хүн амын хүнсний хэрэглээнд мах, гурилан бүтээгдэхүүн зонхилж, эрдэс амин дэмийн гол эх үүсвэр болдог жимс, жимсгэнэ, нарийн ногоо бага хэвээр байгаа нөхцөлд бусад илчлэг сайтай хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, байгалийн гаралтай эко бүтээгдэхүүнээр иргэдээ хангах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дэд хөтөлбөрүүдэд суурилсан төсвийг тухайн жилийн төсөвт хөтөлбөр тус бүрээр төлөвлөлгүй “Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний зардалд батлахдаа хавсралтын дагуу дэд хөтөлбөр бүрээр тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт, тухайн жилд хүрэх тоо хэмжээний үзүүлэлт; зарцуулах төсвийг тооцоогүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ:

1. Замын-Үүд сумын ХМХА-ны лабораторийг яаралтай ашиглалтад оруулах талаар холбогдох албан тушаалтанд уламжлах.
2. Хүнсний аюулгүй байдлыг хангах, сорилт шинжилгээг гүйцэтгэх хүчин чадалтай сорилтын лабораторийн барилга барих, хүнс болон ундны ус, бохир ус, хөрсөнд хүнд металл тодорхойлох атом шингээлтийн багаж оношлуур, лабораторийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр хүчин чадлыг нэмэгдүүлэхэд аймгийн МХГ-ын Сорилтын лабораторид дэмжлэг үзүүлэх талаар МХЕГ-т уламжлах.
3. Орон нутагт гол нэрийн хүнсний үйлдвэртэй болгох нэгдсэн бодлого гаргаж хэрэгжүүлэх талаар эрх бүхий байгууллагад уламжлах.
4. Сумдын ЗДТГ-ын хүнсний асуудал хариуцсан байцаагчийн эрхгүй мэргэжилтнүүдэд улсын байцаагчийн эрх олгох асуудлыг холбогдох албан тушаалтанд уламжилж өгнө үү.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. “Хүнсний ногоо”, “Жимс жимсгэнэ”, “Орон нутгийн экологийн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх” аймгийн дэд хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангаж ажиллах.
2. Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулсан зөрчлийн суурь шалтгааныг тодорхойлж арилгах, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, нутгийн захиргаа болон салбар хоорондын хамтын ажиллагааны үр дүнтэй тодорхой арга хэлбэрийг хэвшүүлэн ажиллах.
3. Хүнсний тухай хуулийн 6.3-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.
4. Хүнсний тухай хуульд заасны дагуу “стратегийн хүнсний үйлдвэрлэл”, “хүүхдийн хоол тэжээл болон органик хүнсний үйлдвэрлэл” зэрэгт төрөөс хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд дэмжлэг, урамшуулал үзүүлж хамтран ажиллах.
5. Сангийн сайдын баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.5.6-д заасны дагуу хөтөлбөр арга хэмжээний төсвийн захирагчийн нэр, хөтөлбөрийн нэр, тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт, тухайн жилд хүрэх тоо хэмжээний үзүүлэлт; зарцуулах төсвийг хавсралтын дагуу гаргах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД

АУДИТОР

Т.МӨНХТОГТОХ

АУДИТОР

Д.ДЭМБЭРЭЛСҮРЭН

ХЯНАСАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

У.ОЮУНТҮЛХҮҮР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

№1



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас/Факс: (976) 7052 3036,
И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn, Вэбсайт: dornogovi.gov.mn

2021.11.08 № 03/1390
танай 2021.11.04 -ны № 1-6/576 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

Танайхаас 2021 оны 1-6/576 тоот албан бичгээр ирүүлсэн “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа.

Тайлангийн төсөлд тусгах саналгүй болно.

ДАРГА



Н.ХОНГОРЗУЛ

44 8211100

№2



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

44105 Дорноговь аймаг, Сайншанд сум, 2 дугаар баг,
Утас: (705) 2-23-52

Вэб сайт: p_dg@inspection.gov.mn

2021. 11. 08 № 2/392
танай 2021. 11. 04-ны № 1-6/578-Т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

Танай байгууллагаас 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн 1-6/578 дугаартай албан тоотод тусгагдсан "Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн" сэдэвт 36 хуудастай гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Аудитын тайлантай холбоотой санал хүсэлт байхгүй болно.

ДАРГА



М.МӨНХБАЯР

№3



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

44105 Дорноговь аймаг, Сайншанд сум, 2 дугаар баг.

Утас/факс: (705) 2-35-54

И-мэйл: Nhaag8@gmail.com

2021. 11. 08 № 164

танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

“Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Нэмэлт саналын хувьд сумдын Засаг Даргын Тамгын газрын Хүнсний асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд Улсын байцаагчийн эрх олгон ажиллуулах нь хяналт тавих өнөөгийн тогтолцоог хэрэгжүүлэхэд илүү үр дүнтэй тул энэ асуудлыг шийдвэрлэхэд Төрийн албаны зөвлөл болон холбогдох бусад байгууллагуудад хүсэлтийг уламжлан шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

ДАРГА

Ж. НАРАНБОЛД



D/Doc/Alban bichig/A4/2021

442210041

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

1. Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн саналыг Үндэсний аудитын газарт уламжиллаа.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/33

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3, 2.4, 2020 оны А/106 дугаар “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” тушаалын 18.9, 2021 оны А/28 дугаар “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг даргад зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газарт хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

